



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар Х/Д/111

Булган сум

Рашаант сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг  
олгох тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 21 дүгээр зүйлийн 21.2, 30 дугаар зүйлийн 30.1.11 дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтын 7.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Рашаант сумын Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хүчин төгөлдөр хугацааг сунгасугай.

2. Ерөнхий боловсролын сургуулийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Ганболд)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ